

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа	2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: Айтүүлс ХК УБГД: 9010001141 Үнэт цаасны код: 543 Утас: 75755585 Имэйл: info@itools.mn , secretary@itools.mn Фэйсбүүк: Айтүүлс ХК	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Мэдээллийн технологи, харилцаа холбоо /Дата төвийн үйлчилгээ/	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	34,452,124	
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Нягтлан бодогч: Б.Өнөрбадрах Борлуулалтын мэргэжилтэн: Д.Жигжид ТУЗ-ийн н/б дарга: Ч.Жаргал Гүйцэтгэх захирал: Ч.Мөнхжаргал	
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг Нэгдүгээр хавсралтаар хүргүүлэв.
	Орлогын тайлан	
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	
	Мөнгөн гүйлгээний тайлан	

2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт							
	Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хурлаар Айтүүлс ХК-ийн 2023 оны нэгдүгээр хагас жилийн тайланг хэлэлцэнэ.							
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт							
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<table><tr><td>Цэвэр ашгийн хувь</td><td>10.0%</td></tr><tr><td>Өөрийн хөрөнгийн өгөөж</td><td>5.0%</td></tr><tr><td>Нийт хөрөнгийн өгөөж</td><td>3.8%</td></tr></table>	Цэвэр ашгийн хувь	10.0%	Өөрийн хөрөнгийн өгөөж	5.0%	Нийт хөрөнгийн өгөөж	3.8%
Цэвэр ашгийн хувь	10.0%							
Өөрийн хөрөнгийн өгөөж	5.0%							
Нийт хөрөнгийн өгөөж	3.8%							
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<table><tr><td>Нэгж хувьцаанд ногдох ашиг</td><td>5.41</td></tr><tr><td>Эргэлтийн харьцаа</td><td>0.15</td></tr><tr><td>Түргэн хөрвөх чадварын харьцаа</td><td>5.5</td></tr></table>	Нэгж хувьцаанд ногдох ашиг	5.41	Эргэлтийн харьцаа	0.15	Түргэн хөрвөх чадварын харьцаа	5.5
Нэгж хувьцаанд ногдох ашиг	5.41							
Эргэлтийн харьцаа	0.15							
Түргэн хөрвөх чадварын харьцаа	5.5							
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Үйл ажиллагааны тайланг Хоёрдугаар хавсралтаар хүргүүлэв.						
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.						
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/							
	Тайлант хугацаанд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй.							
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл							

	Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.
5.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i> Компани нь ХЭЭХ-ыг 4-р сарын 15-ны өдөр танхимаар амжилттай зохион байгуулж, хурлын тайлан материалыг СЗХ болон МХБ-д хүргүүлсэн. Тус хурлаар ТУЗ-ийг дараах бүрэлдэхүүнтэй сонгосон бөгөөд ТУЗ нь дарга болон Хороодын гишүүдийн хуваарилалтыг хийсэн. Айтүүлс ХК-ийн ТУЗ-ийн гишүүд, хороод: 1. ТУЗ-ийн дарга Г.Хатанболд ТУЗ-ийн ердийн гишүүн А. Баттамир ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Амгаланбаатар ТУЗ-ийн ердийн гишүүн Н.Улаанхүү ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Даваа ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Тамир ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Гантуяа ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Жавхлан ТУЗ-ийн хараат бус гишүүн З.Саранчимэг 2. <u>ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо:</u> Дарга – Н.Жавхлан Гишүүд – З.Саранчимэг, Б.Амгаланбаатар 3. <u>ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо</u> Дарга – Д.Даваа Гишүүд – З.Саранчимэг, Г.Гантуяа 4. <u>ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо</u> Дарга – Г.Хатанболд Гишүүд – Г.Гантуяа, Н.Жавхлан 5. <u>ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга</u> ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Янжилхам нь жирэмсний болон амаржих, хүүхэд асрах чөлөө авсан тул Ч.Жаргалыг 6-р сарын 2-ны өдрөөс шинээр томилсон. Ч.Жаргал нь Компанийн засаглалын сургалтад сууж, гэрчилгээ авсан, компанийн засаглалын чиглэлээр ажлын туршлагатай болно.
6.	<i>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</i> Шинээр байгуулагдсан ТУЗ нь Компанийн дүрэм, журамд заасны дагуу улиралд нэг удаа ээлжит хурал хийхээр төлөвлөсөн ба 5-р сарын 4-ний өдөр анхны хурлаа хийж, 2-р улирлын тайланг хэлэлцэх хурлыг 7-р сарын 25-ны өдөр хийхээр төлөвлөн ажиллаж байна. Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх явцыг дотооддоо үнэлэх Компанийн засаглалын үнэлгээний тайланг СЗХ-нд 6-р сард хүргүүлсэн ба үнэлгээ дээшилж 85.6% болсон хэдий ч дунд засаглалтайд тооцогдож байна. Улмаар 2023 онд багтаан засаглалыг сайжруулах ажлуудыг төлөвлөн ажиллаж байна. /Компанийн засаглалын үнэлгээний тайланг хавсаргав/ Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Чимэдхишигийн Мөнхжаргал Албан тушаал: "Айтүүлс" ХК-ийн Гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга/тэмдэг)	Овог, нэр: Албан тушаал: "....." ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга/тэмдэг)
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Ч.Жаргал Албан тушаал: Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Гарын үсэг:	

ХАВСРАЛТ №1

Сангийн сайдын 2017 оны
361 дугаар тушаалын
.... дугаар хавсралт

Регистрийн дугаар: 5468361

Хаяг : Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Реженси Резиденс 201 тоот

Шуудангийн хаяг : _____

Утас : 75755585

Факс :

Өмчийн хэлбэр :

Төрийн хувь

хувийн 100 хувь.



АЙТҮҮЛС ХК-ийн
2023 ОНЫ 2 УЛИРАЛЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН



	Сар, өдөр	Гарын үсэг

Санхүүгийн байдлын тайлан

Айтүүлс ХК

(Аж ахуйн нэгжийн нэр)

/төгрөгөөр/

Тайлант үе:

2023/01/01 - 2023/06/30

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 01-р сарын 01	2023 оны 06-р сарын 30
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	483,470,086.85	315,574,680.16
1.1.2	Дансны авлага	693,607,167.46	1,037,366,084.32
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	99,000.00	0.00
1.1.4	Бусад авлага	17,974,819.74	14,155,726.60
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	145,830,198.57	145,830,198.57
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	36,021,183.37	154,308,354.94
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.10	...	0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,377,002,455.99	1,667,235,044.59
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,560,937,332.52	3,425,074,369.57
1.2.2	Биет бус хөрөнгө	27,277,776.56	29,571,109.27
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	70,446,145.00	80,446,145.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.9	...	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,658,661,254.08	3,535,091,623.84
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,035,663,710.07	5,202,326,668.43
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	52,891,498.05	54,186,492.14
2.1.1.2	Цалингийн өглөг	262,742.86	22,012,028.79
2.1.1.3	Татварын өр	174,642,594.84	80,348,500.37
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	36,428,820.00	87,956,156.63
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.12	...	0.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	264,225,655.75	244,503,177.93
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	997,000,000.00	997,000,000.00
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.5	...	0.00	0.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	997,000,000.00	997,000,000.00

2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,261,225,655.75	1,241,503,177.93
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	0.00	0.00
2.3.2	Хувийн өмч	1,481,441,363.28	1,481,441,363.28
2.3.3	Хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	763,114,860.00	763,114,860.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	460,721,652.19	460,721,652.19
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	0.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,069,160,178.85	1,255,545,615.03
2.3.10	...	0.00	0.00
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,774,438,054.32	3,960,823,490.50
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	5,035,663,710.07	5,202,326,668.43

Гүйцэтгэх захирал

Нягтлан бодогч

Ч.Мөнхжаргал

Б.Өнөрбадрах



Орлогын дэлгэрэнгүй тайлан

Айтүүлс ХК

Тайлант үе: 2023/01/01 - 2023/06/30

(Аж ахуйн нэгжийн нэр) /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,877,499,813.66	1,906,828,659.87
2	Борлуулалтын өртөг	2,303,172,617.20	1,277,933,392.53
3	Нийт ашиг (алдагдал)	1,574,327,196.46	628,895,267.34
4	Түрээсийн орлого	52,181,818.19	21,090,909.10
5	Хүүгийн орлого	0.00	2,077,331.40
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	10,835.46
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	95,175,735.64
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,331,037,631.92	223,378,607.67
11	Санхүүгийн зардал	0.00	119,640,000.00
12	Бусад зардал	2,843,608.00	7,974,691.65
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	4,122,835.26	1,490,115.10
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	4,177,117.86	585,582.50
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	300,927,727.85	207,981,005.94
19	Орлогын татварын зардал	30,377,133.59	21,595,569.76
20	Татварын дараах ашиг (алдагдал)	270,550,594.26	186,385,436.18
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	270,550,594.26	186,385,436.18
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	270,550,594.26	186,385,436.18
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

Гүйцэтгэх захирал

Ахлах нягтлан бодогч



Ч.Мөнхжаргал

Б.Өнөрбадрах

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант үе: 2023/01/01 - 2023/06/30

Айтуулс ХК
(Аж ахуйн нэгжийн нэр) /төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,481,441,363.28	0.00	763,114,860.00	460,721,652.19	0.00	0.00	798,609,584.59	3,503,887,460.06
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	1,481,441,363.28	0.00	763,114,860.00	460,721,652.19	0.00	0.00	798,609,584.59	3,503,887,460.06
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
6	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,481,441,363.28	0.00	763,114,860.00	460,721,652.19	0.00	0.00	1,069,160,178.85	3,774,438,054.32
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	1,481,441,363.28	0.00	763,114,860.00	460,721,652.19	0.00	0.00	1,069,160,178.85	3,774,438,054.32
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	186,385,436.18	186,385,436.18
14	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2023 оны 6-р сарын 30-ээрх үлдэгдэл	1,481,441,363.28	0.00	763,114,860.00	460,721,652.19	0.00	0.00	1,255,545,615.03	3,960,823,490.50

Ч.Мөнхжаргал
Б.Өнөрбадрах

Гүйцэтгэх захирал
Нягтлан бодогч



Мөнгөн гүйлгээний тайлан

Айтүүлс ХК

(Аж ахуйн нэгжийн нэр) /төгрөгөөр/

Тайлант үе:

2023/01/01 - 2023/06/30

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 01-р сарын 01	2023 оны 06-р сарын 30
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,706,940,180.48	1,642,275,638.19
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	3,084,784,580.48	1,634,661,378.27
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	622,155,600.00	7,614,259.92
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,223,354,009.10	1,603,825,722.61
1.2.1	Ажилагсад төлсөн	412,442,542.72	235,246,556.22
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	118,710,057.66	74,908,360.03
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,063,290,123.00	794,309,153.50
1.2.5	Ашиглалтын зардалд төлсөн	134,792,143.82	93,252,802.89
1.2.6	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,448,045.46	1,249,900.00
1.2.7	Хүүний төлбөрт төлсөн	191,280,000.00	64,476,000.00
1.2.8	Татварын байгууллагад төлсөн	100,942,926.55	281,550,950.49
1.2.9	Даатгалын төлбөрт төлсөн		3,321,860.63
1.2.10	Бусад мөнгөн зарлага	193,448,169.89	55,510,138.85
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	483,586,171.38	38,449,915.57
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	625,130,072.89	84,799,491.26
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	20,320,000.00	110,000.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө боруулсаны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	604,810,072.89	82,612,159.86
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	2,077,331.40
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	869,982,623.38	249,965,187.94
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	319,433,195.48	85,500,188.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	5,599,000.01
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	10,000,000.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	550,549,427.90	148,865,999.93
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-244,852,550.49	-165,165,696.68
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	74,161,750.00	4,810,426.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	74,161,750.00	4,810,426.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	82,099,547.94	47,616,697.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	82,099,547.94	47,616,697.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-7,937,797.94	-42,806,271.00
4	Вальютын ханшийн зөрүү	2,541,606.05	1,626,645.41
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	233,337,429.00	-167,895,406.69
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	250,132,657.85	483,470,086.85
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	483,470,086.85	315,574,680.16

Гүйцэтгэх захирал

Нягтлан бодогч

Ч.Мөнхжаргал

Б.Өнөрбадрах



ШТК1646 9023010614 5468361

ХАВСРАЛТ №2

2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Улаанбаатар хот

2023 он

АГУУЛГА

1 КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

- ☞ Компанийн тухай
- ☞ Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйл
- ☞ ТУЗ-ын гишүүдийн танилцуулга
- ☞ Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

2 БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ☞ 2023 оны хагас жилийн үйл ажиллагааны товч тайлан
- ☞ Зах зээлд шинээр нэвтрүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээ
- ☞ 2023 оны хагас жилд оролцсон арга хэмжээнүүд

1. КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

КОМПАНИЙН ТУХАЙ

Манай компани нь Монгол Улсад мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд 2012 оноос эхлэн домэйн нэрийн бүртгэл, веб хост, сервер байршуулалт, виртуал серверийн түрээс, и-мэйл сервисийн ашиглалт зэрэг интернет технологид суурилсан бүтээгдэхүүн, үйчилгээг аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүст үзүүлж тэдгээрийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг ханган ажилласаар ирсэн. Компани нь өнгөрсөн 11 жилийн хугацаанд мэдлэг чадвартай ажилтан, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нийлүүлэн салбарынхаа тэргүүлэх компани болохыг зорьж ажилласан ба 2017 оны 09 сараас эхлэн өмчийн хэлбэрээ өөрчлөн, хувьцаат компани болсон.

Эрхэм зорилго

Дижитал орчны үнэ цэнийг хүчирхэгжүүлэх найдвартай суурь нь байна.

Алсын хараа

Дэлхийн жишигт нийцсэн дата төвд хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, эргэлзээгүй сонголтыг бий болгоно.

Үнэт зүйлс

Бид - Үнэнч хариуцлагатай

Бид дэлхийд өрсөлдөх чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэхдээ ямагт үнэнч байж цаг хугацаандаа хариуцлагатай үйлчилгээг үзүүлдэг хамт олон.

Бид – Чадварлаг

Бид мэдээллийн технологийн чиглэлээр өндөр түвшинд бэлтгэгдсэн чадварлаг хамт олон.

Бид - Эелдэг

Бид хэрэглэгч нартаа цаг ямагт эелдэг боловсон хүнлэг хандаж, тулгарсан асуудлыг нь шийдэхдээ ямагт найрсаг үйлчилгээг үзүүлдэг баг, хамт олон.

Бид - Стандарт хэрэгжүүлэгч

Бид хууль эрх зүйн хэм хэмжээг нягт сахин баримталж зохих стандарт горимын дагуу хэрэглэгч, харилцагчийн эрэлт хэрэгцээг бүрэн хангасан үйлчилгээ үзүүлдэг хамт олон.

Бид -Хурдан шуурхай

Бид харилцагч, хэрэглэгчийн хүссэн цаг хугацаанд хүссэн үйлчилгээ, тулгарсан асуудал, хүсэлт, саналыг эн тэргүүнд харгалзан үздэг шуурхай хамт олон.

Бид - Бүтээлч

Бид ямагт шинэлэг оновчтой санааг бүтээгдэхүүн үйлчилгээндээ нэвтрүүлдэг бүтээлч хамт олон

ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН



ТУЗ-ийн дарга

Г.Хатанболд

Санхүүгийн удирдлагын магистр
"Ай Си Ти Групп" ХК-ийн
Үйл ажиллагаа хариуцсан
захирал



ТУЗ-ийн хараат бус гишүүн

Г.Гантуяа

Бизнесийн удирдлагын докторант
Номадик контент ХХК-ийн
үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх
захирал



ТУЗ-ийн хараат бус гишүүн

Н.Жавхлан

Бизнесийн удирдлага, Төрийн
удирдлагын магистр
Могол Консалтинг ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



ТУЗ-ийн хараат бус гишүүн

З.Саранчимэг

Эрх зүйн ухааны магистр
Ачтан эмнэлэгийн Хүний
нөөцийн менежер



ТУЗ-ийн ердийн гишүүн

А.Баттамир

Техникийн ухааны магистр
Ай Си Ти групп ХК-ийн
үүсгэн байгуулагч



ТУЗ-ийн ердийн гишүүн

Б.Амгаланбаатар

Нягтлан бодогч
Ай Си Ти групп ХК-ийн
Санхүү хариуцсан
захирал



ТУЗ-ийн ердийн гишүүн

Н.Улаанхүү

Эдийн засгийн онолч,
эдийн засагч
Ай Си Ти групп ХК-ийн
Хөрөнгө оруулалт
хариуцсан захирал



ТУЗ-ийн ердийн гишүүн

Б.Тамир

Улс төрийн удирдлагын магистр
Ай Си Ти групп ХК-ийн
Хамтын ажиллагаа,
борлуулалт маркетингийн
газрын захирал



ТУЗ-ийн ердийн гишүүн

Д.Даваа

Програм хангамжийн инженер
Ай Си Ти групп ХК-ийн
төлбөр тооцоо хариуцсан
захирал





ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Г.Янжинлхам

Нийтийн удирдлага магистр,
эрх зүйч

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн ТУЗ-ийн 2023 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 23/009 тоот тогтоолоор 2023 онд байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн баталж нийт 1 алба, 6 хэлтэс, 29 ажлын байртайгаар үйл ажиллагаа явуулахыг баталсан.

2. 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

АЙТҮҮЛС ХК ISO 9001:2015 ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ГЭРЧИЛГЭЭГЭЭ ГАРДАН АВЛАА



“Айтүүлс” ХК нь хэрэглэгчдэдээ мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан, тасалдалгүй, чанартай бүтээгдэхүүнийг хүргэх, сэтгэл ханамжийг ямагт дээшлүүлэх зорилгоор 2022 оны 3 дугаар улирлаас эхлүүлэн үйл ажиллагаандаа ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо болон ISO/IEC 27001:2013 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо стандартуудыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байсан билээ.

Бид 2022 оны 08 дугаар сараас эхлэн ISO хэрэгжүүлэх төслийн багийг байгуулан стандартыг үе шаттай нэвтрүүлэх төлөвлөгөө гаргаж ажилласан ба 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Олон улсын сургалт, баталгаажуулалтын Мон Майнинг Сертификейшин ХХК-аас “Айтүүлс” ХК-ийн үйл ажиллагаанд аудит хийж, тохирлын үнэлгээ, хяналт шинжилгээгээр ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо олон улсын стандартын шаардлагыг бүрэн хангасан тул ийнхүү баталгаажуулалтын гэрчилгээг гардууллаа.

АЙТҮҮЛС ХК IPV6 АМЖИЛТТАЙ НЭВТРҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ



Өдөр ирэх тусам өсөн нэмэгдэж буй интернэт

хэрэглэгчийн тоо, 5G сүлжээний нэвтрүүлэлт, IoT (Internet of Things) , аюулгүй байдал, IPv4-ийн нөөцийн хомсдол зэргээс хамаараад Интернэтийн протокол хувилбар 6 буюу IPv6-г нэвтрүүлэх чухал шаардлага үүсээд байгаа билээ. APNIC (Ази Номхон Далайн бүсийн сүлжээ мэдээллийн төв)-с гаргаснаар 2022 оны төгсгөлд манай улсын IPv6 нэвтрүүлэлт 5%-д хүрэхгүй үзүүлэлттэй байсан бол 2023 оны 4 дүгээр сарын байдлаар уг үзүүлэлт 15% орчим болж өссөн байна. Айтүүлс ХК нь дэлхий даяар өрнөж буй уг шилжилттэй хөл нийлүүлэн IPv6 нэвтрүүлэлтийг амжилттай хийлээ. Мөн бид 2023 онд нийт бүтээгдэхүүн үйлчилгээний 60%-д IPV6-г нэвтрүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

АЙТҮҮЛС ХК ISO/IEC 27001:2013 ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ГЭРЧИЛГЭЭГЭЭ ГАРДАН АВЛАА




Дата төв, программ хангамж, мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэгч “Айтүүлс” ХК нь хэрэглэгчийн бүрэн бүтэн, нууцлалтай мэдээллийг хадгалах, хамгаалах хүртээмжтэй байдлыг хангахын тулд Олон улсын мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO/IEC 27001:2013 стандартыг 2022 оны 08 дугаар сараас эхлэн үе шаттай нэвтрүүлэх төлөвлөгөө гарган ажилласан билээ.

2023 оны 03 дугаар сарын 29, 30-ны өдөр Олон улсын BSCIC Certifications Pvt.Ltd-с “Айтүүлс” ХК-ийн үйл ажиллагаанд аудит хийж, тохирлын үнэлгээ, хяналт шинжилгээгээр ISO/IEC 27001:2013 стандартын шаардлагыг бүрэн хангасан тул ийнхүү 2023 оны 5 сарын 16-ны өдөр албан ёсоор сертификатаа гардан авлаа.

ДАТА ТӨВИЙН ӨРГӨТГӨЛИЙН АЖИЛ ХИЙГДЛЭЭ.

Айтүүлс ХК-н 2023 оны эхний хагаст дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэн өргөтгөлийн ажлыг хийлээ. Уг өргөтгөлийн ажлын үр дүнд дата төвд байршуулах серверийн тоног төхөөрөмжийн тоо нэмэгдэж байгаа юм.

Мөн 2023 оны эхний хагас жилд Айтүүлс ХК дата төв нь **99.98** хувийн тасалдалгүй ажиллагаатай байсан нь ОУ-н дата төвийн TIER стандартын TIER 3 түвшний үзүүлэлтийг хангахуйц сайн үзүүлэл байлаа.




АЙТҮҮЛС ХК ТЕХНИКИЙН ДЭМЖЛЭГИЙН ХЭЛТЭСТЭЙ БОЛЛОО.

Бид 2023 он 06 дугаар 01 өдрөөс эхлэн техникийн дэмжлэг үйлчилгээ үзүүлэх хэлтэстэй боллоо. Техникийн дэмжлэг үйлчилгээний хэлтэс нь хэрэглэгчдэд стандартад нийцсэн сервер, системийн ашиглалтын дараах дэмжлэг, техникийн тусламж үйлчилгээг цогцоор нь санал болгож байна. Ингэснээр хэрэглэгчдэдээ системийн, серверийн арчилгаанд зарцуулах цаг, хүний нөөц, санхүүгийн зардлыг хэмнэх боломжийг олгож байна.

ЗАХ ЗЭЭЛД ШИНЭЭР НЭВТРҮҮЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

АЙТҮҮЛС ХК 2023 оны 02 дугаар сараас эхлэн MICROSOFT корпорацийн албан ёсны хамтрагч байгууллага боллоо.

Ингэснээр хэрэглэгчид Microsoft корпорацийн зах зээлд нийлүүлж байгаа бүх төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ, программ хангамжийн лицензийг Айтүүлс ХК-с аван ашиглах боломжтой болсон юм. Microsoft корпорацийн бүтээгдэхүүн үйлчилгээ нь танд болон танай хамт олонд хаанаас ч, хэзээ ч цаг алдалгүй харилцах боломж хамтын ажиллагааг илүү үр дүн өндөр бүтээмжтэй ажиллах боломжийг олгох ба аюулгүй найдвартай байдлыг санал болгоно.



ИЛҮҮ ХУРДАН, ИЛҮҮ ХЯЛБАР-р веб сайтаа удирдах боломж бүхий WORDPRESS хостинг үйлчилгээг нэвтрүүллээ.

Айтүүлс ХК нь хэрэглэгчдэдээ олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх зорилтын хүрээнд таны веб сайтыг ИЛҮҮ ХУРДАН ажиллах, ИЛҮҮ ХЯЛБАР-аар веб сайтаа удирдах боломж бүхий **WordPress хостинг** үйлчилгээг 2023 оны 4-р сараас эхлэн нэвтрүүлээд байна. WordPress нь дэлхийн хамгийн өргөн хэрэглэгддэг веб сайт бүтээх CMS/Content Management System/ буюу агуулгыг удирдах систем юм.

Энэхүү системийг ашиглаж жижиг хэмжээний блог, байгууллагын танилцуулга веб сайтаас эхлүүлэн TIME Magazine, Sony Music, Microsoft News зэрэг дэлхийн томоохон компаниуд хүртэл өөрсдийн веб сайтыг уг CMS-г ашиглан бүтээж байна. Учир нь WordPress нь дэлхийн өнцөг булан бүрд байгаа өндөр түвшний мэргэжлийн веб дизайнер, веб хөгжүүлэгч нарийн бүтээсэн content-уудаас өөрийн сайт, системд тохирохыг хүссэнээрээ сонгож өөрийн веб сайтаа хялбараар бүтээх боломжийг олгодог. 2023 оны байдлаар дэлхий нийтээр ажиллаж буй нийт веб сайтын 43.5% нь WordPress дээр ажиллаж байна.

Айтүүлс ХК -н шинээр нэвтрүүлж буй WordPress хостын үйлчилгээ нь тусгай зориулалтын Web Cache ашиглаж байгаа тул веб сайтын унших хурдыг хурдасгахаас гадна CDN технологи идэвхжүүлэх боломжтой нь дэлхийн хаанаас ч хурдан хандах боломжийг олгож байна.

Дагуу тал

- Тусгай зориулалтын Web Cache ашиглаж байгаа тул веб сайтын унших хурдыг хурдасгана.
- CDN технологи идэвхжүүлэх боломжтой тул дэлхийн хаанаас ч Монголоос хандаж буй мэт хандах боломжийг бий болгоно.
- SSL сертификат үнэгүй дагалдах тул таны веб сайттай холбогдолтой үйлдлүүд найдвартай, аюулгүй хамгаалалттай байна.
- Ганцхан товшилтоор веб сайтаа үүсгэх боломжтой.
- 24/7 тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой.
- Өдөр бүр серверийн нөөцлөлт /Backup/ хийгдэнэ.

Веб байршуулах үйлчилгээ SSD storage болон CACHE-тэй болон шинэчлэгдлээ.

Жилээс жилд технологийн төхөөрөмжүүд ашиглахад илүү хялбар, өндөр хүчин чадал бүхий болсоор байгаа нь хэрэглэгчдэд үр ашигтай ажиллах боломжийг олгож байна. Бидний өдөр тутам хэрэглэгддэг төхөөрөмжүүдээс таны илгээж, ашиглаж байгаа файлуудыг хадгалах үндсэн 2 төрлийн ойлголт байдаг нь HDD болон SSD storage юм. Өөрөөр хэлбэл таны веб сайтын багтаамж, хандалтын хурд зэрэг нь хостинг үйлчилгээний хадгалах төхөөрөмжөөс шууд шалтгаалдаг гэсэн үг юм.



Тэгвэл SSD storage гэж яг юу вэ? (Solid-state drive)

SSD storage нь энгийнээр мэдээлэл хадгалах санах ой буюу сүүлийн үеийн өгөгдөл хадгалах технологи юм. SSD нь ерөнхийдөө флаш дисктэй ижил технологийг ашигладаг боловч илүү өргөн цар хүрээтэй. SSD storage нь хэд хэдэн санах ойн эсүүдийг агуулсан санах ойн чипүүдээс бүрддэг бөгөөд үндсэн гурван төрлийн санах ойн эсүүдийг авч үздэг:

Нэг түвшний эсүүд (SLC)

Олон түвшний эсүүд (MLC)

Гурвалсан түвшний эсүүд (TLC)

SLC нь зөвхөн хоёр бит өгөгдөл (а 1 эсвэл 0) багтаах боломжтой бөгөөд энэ нь илүү өндөр түвшний нарийвчлал, гэхдээ өндөр өртөгтэй гэсэн үг юм. MLC нь нэг нүдэнд хоёр бит өгөгдөл агуулдаг ба TLC нь гурав буюу битийн өсөлт бүр нь нарийвчлал, хурдыг өөрчлөхөд хүргэдэг боловч илүү өндөр үнээр авах боломжтой гэсэн үг юм.

Бид яагаад HDD-с SSD storage-руу шилжих шаардлагатай вэ?

1. Илүү хурдан
2. Дуу чимээ бага
3. Хэрэглэхэд хялбар
4. Эрчим хүчний хэрэглээ бага
5. Хөнгөн бөгөөд зөөвөрлөхөд Хялбар


Ерөнхийдөө таны веб сайтын хурдан ажиллах, өндөр хандалт авах хүчин чадал зэрэг нь таны сонгосон хостинг үйлчилгээний үзүүлэлттэй шууд хамааралтай байдаг тул та хостинг үйлчилгээг сонгохдоо дээрх үзүүлэлтүүдийг сайтар авч үзэх шаардлагатай.

Айтүүлс ХК-н веб байршуулах үйлчилгээний бүх багцууд SSD storage болсноор

- Хэрэглэгчдийн веб сайт дуудагдах хугацаа 9-15 дахин хурдан болохоос гадна
- Унших, бичих хурд 10 дахин сайжирч
- Backup нөөцлөлтийн хурд 5 дахин нэмэгдэнэ.
- Өөрөөр хэлбэл өмнө нь 1 минутанд 10 хэрэглэгч таны веб сайт руу 170 удаа хандах боломжтой байсан бол SSD хард Cache-болсноор 1700 удаа хандах боломжтой гэсэн үг юм.

Мөн бид одоогоор HDD storage бүхий веб байршуулах үйлчилгээ ашиглаж байгаа хэрэглэгчдийн вебсайтыг SSD storage-тэй веб байршуулах үйлчилгээнд үнэ төлбөргүйгээр шилжүүлж байна.

2023 ОНЫ ХАГАС ЖИЛД ОРОЛЦСОН АРГА ХЭМЖЭЭНҮҮД



Мөн арга хэмжээний хүрээнд Дижитал шилжилтийн талаар мэргэжилтнүүдийн сонирхолтой илтгэлүүд болон нээлттэй хэлэлцүүлгүүд амжилттай болж өрнөлөө.

Айтүүлс ХК нь “Нээлттэй Ирээдүй – Дижитал Дархан 2023” арга хэмжээнд хамтран зохион байгуулагчаар оролцлоо.

Айтүүлс ХК нь Голомт банкнаас санаачлан зохион байгуулсан “Дижитал Дархан 2023” арга хэмжээнд хамтрагч байгууллагаар оролцон өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээ болон үйл ажиллагааны талаар мэдээллийг Дархан хотын иргэд, аж ахуй нэгжүүдэд хуваалцлаа. 2023.03.03-04-ний өдрүүдэд Дархан хотын “Залуучууд” театрт зохион байгуулагдсан уг арга хэмжээний үеэр нийт 40+ мэдээлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулсан үзэсгэлэн зохион байгууллаа.

Momade Agency-с зохион байгуулсан MOM 2.0 Mongolia арга хэмжээний ивээн тэтгэгчээр оролцлоо.

Momade Agency нь 2020 оноос хойш виртуал туслахын салбарт гэрээсээ ажиллах хүсэлтэй ээжүүдийг чадавхижуулах, онлайн орчинд ажлын байраар хангах чиглэлд тасралтгүй үйл ажиллагаа явуулсаар ирсэн юм. Айтүүлс ХК 2023 оны 4 сарын 1 өдөр Corporate Convention Center-т зохион байгуулагдсан "MOM 2.0: Маркетинг, технологи, бизнес сонирхогч 1000 ээжийн чуулга уулзалт" арга хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцлоо. Энэхүү арга хэмжээ нь “Технологи бол кодчилал, кодын чадвар бол эрэгтэйчүүд гэсэн нийтлэг ойлголтыг халж, хэрэглээний апп, NO CODE, AI, зэрэг нь яг л ухаалаг будаа агшаагчийн адил ойлгоход

хялбар, ашиглахад амархан, өдөр тутмын хэрэглээ болохыг ээжүүдэд ойлгуулах зорилготой болсон юм.



TECH IS UNLIMITED уриатайгаар “ICT EXPO 2023”-д амжилттай оролцлоо.

Мэдээлэл технологи харилцаа холбооны салбарын хамгийн том арга хэмжээ болох “ICT Expo 2023” 6-р сарын 9-ний өдрөөс эхлэн 6-р сарын 11-ний өдрийг дуустал гурав хоногийн турш амжилттай зохион байгуулагдлаа. ICT Expo 2023-н хувьд Paperless буюу цаасан хэвлэл ашиглахгүй байснаараа өмнөх жилүүдээс онцлог болж өнгөрсөн бөгөөд Айтүүлс ХК-н хувьд “TECH IS UNLIMITED” уриан дор брошюр, цаасан хэвлэл ашиглахгүй бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулах боломж бүхий Webdy- Хялбар веб сайт угсрах үйлчилгээгээ онцоллоо.

ICT Group zone-н хувьд Ай Си Ти группийн салбар компаниуд нэг Booth-д байршсанаар хэрэглэгчдэд нэг дороос технологийн интеграци шийдлүүдийг цогц байдлаар хүргэх боломжийг олгосон. Айтүүлс ХК нь сонирхолтой, хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулж, оролцсон хүн бүрд компанийн гарын бэлэг болон ялагчдад 100% үнэ төлбөргүй WEBDY үйлчилгээг ашиглах эрхийн бичиг гардууллаа.

Үзэсгэлэнгийн талбайгаар зочилж, Дата төв, дижитал шийдлүүд, бүтээгдэхүүн үйлчилгээнүүдтэй танилцсан нийт хэрэглэгчдэдээ баярлалаа.



ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Айтүүлс ХК нь бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ чанар болон үйл ажиллагааг илүү сайжруулах зорилгоор хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг байнгын авч байна. Та ердөө 3-хан минутын хугацааг зарцуулан СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА-нд хамрагдана уу.

Бид судалгааны үр дүнд үндэслэн бүтээгдэхүүн үйлчилгээний чанар болон үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулан ажиллах болно.

Судалгаанд хамрагдах бол [ЭНД ДАРНА](#) уу.